

Төсөл

## АЮУЛТАЙ БАЙГУУЛАМЖ БАЙРЛУУЛАХ ЗАЙ, ОГТЛОЛЦЛЫН БОЛОН БАЙРШЛЫН НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар аюултай байгууламж, бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай дамжуулах хоолой, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжийг төмөр замтай огтлолцуулах үед баримтлах зай хэмжээ, байршил, түвшин, техникийн нөхцөлийг тогтоож, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам эзэмшигч, иргэн, тээвэрлэгч, цахилгаан, дулаан, авто зам, бусад байгууламжийг эзэмшигч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Хүсэлт гаргагч тал нь төмөр замтай огтлолцуулах байршил, түвшинг тогтоолгох, зөвшөөрөл олгох асуудлыг дараах дарааллын дагуу ажиллана:

1.2.1. Хүсэлт гаргагч нь авто зам, явган хүний гарц, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламж, аюултай байгууламж, бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай дамжуулах хоолойг төмөр замтай огтлолцуулах байршил, түвшинг тогтоох хүсэлтийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

1.2.2. хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргасан байна:

- инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжийн танилцуулга;
- техник эдийн засгийн урьдчилсан судалгаа;
- дэвсгэр зураг;
- техникийн нөхцөл;
- Бусад баримт бичиг /газрын гэрээ, гэрчилгээ, орон нутгийн зөвшөөрөл, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжийн асуудал хариуцсан байгууллагын шийдвэр;

1.2.3. төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжийн хүчин чадал, хамрах хүрээнээс хамаарч төмөр замтай огтлолцуулах байршил, түвшинг тогтоож, зөвшөөрөл олгохыг тухайн суурь бүтэц эзэмшигч, дагнасан хэрэглээний төмөр зам эзэмшигчид хариуцуулж болно.

1.2.4. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш хуульд заасан хугацаанд ажлын хэсгийг байгуулж, дүгнэлт гаргана. Дүгнэлтэд техникийн нөхцөл, огтлолцлын байршил, түвшинг тодорхойлсон, огтлолцол боломжгүй бол түүнийг нотолсон баримт бичиг зэргийг хавсарган хүсэлт гаргагчид өгнө.

1.2.5. Дүгнэлтэд техникийн нөхцөл, огтлолцлын байршил, түвшинг тодорхойлсон, огтлолцлыг зөвшөөрсөн дүгнэлт нь зураг төсөл боловсруулах үндэслэл болно. Дүгнэлт нь 1/нэг/ жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

1.2.6. Хүсэлт гаргагч шийдвэр, суурь бүтэц болон тухайн төмөр замыг эзэмшигч нарын зөвшөөрөл түүнд хавсрагдсан техникийн нөхцөлийг үндэслэн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар зураг төсөл хийлгэнэ.

1.2.7. Зураг төслийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, суурь бүтэц болон тухайн төмөр замыг эзэмшигч нараар хянуулж, зөвшилцөнө. Суурь бүтэц эзэмшигч нь төмөр замтай огтлолцуулсан инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжийн талаарх мэдээллийг бүртгэлжүүлсэн байна.

1.2.8. Зураг төсөлд холбогдох чиглэлийн эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэх эсэхийг инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн төвөгшил, хэмжээнээс хамаарч Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсэг дүгнэлтэд тусгана.

1.2.9. Барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч, суурь бүтэц болон тухайн төмөр замыг эзэмшигч нарын хяналт дор ажлыг гүйцэтгэнэ.

1.2.10. Барилгын ажлыг гүйцэтгэхэд галт тэрэгний хөдөлгөөнийг зогсоож хийх шаардлагатай тохиолдолд суурь бүтэц эзэмшигч тухайн ажлыг гүйцэтгэх огноо, технологийн "Цонх"-ны үргэлжлэх хугацаа, ажлын хэмжээ, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангаж, холбогдох арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэнэ.

1.2.11. Зураг төсөл боловсруулагч барилгын ажил эхлэх үед улаан шугам тавих, ажлын явцад зохиогчийн хяналт тавих, ажил дууссаны дараа гүйцэтгэлийн зураг хийнэ.

1.2.12. Барилгын ажил дууссан тухай төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад талуудын ирүүлсэн мэдээллийг үндэслэн ажлын хэсэг газар дээр нь судалж, ажлын зургийг гүйцэтгэлийн зурагтай харьцуулж хянан хангалттай гэж үзвэл байнгын ашиглалтад хүлээж авах акт үйлдэн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа талаар дүгнэлт гарган хоёр талд өгнө.

1.2.13. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжыг ашиглалтад хүлээн авахдаа шаардлагатай тохиолдолд техникийн комисс ажиллуулах бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, дүгнэлт гаргана. Шаардлагатай бол техникийн туршилт хийнэ.

1.2.14. Инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламжыг төмөр замтай огтлолцуулах зөвшөөрөл олгох үйл ажиллагааны болон суурь бүтцийн байгууламж, төхөөрөмжийг шилжүүлэх зардлыг хүсэлт гаргагч тал хариуцна.

## **Хоёр. Дамжуулах хоолойг төмөр замтай огтлолцуулах**

### **2.1. Дамжуулах хоолой.**

2.1.1. Байгалийн хий дамжуулах хоолойг түүн доторх хийн ажлын даралтын /цаашид даралт гэх/ хэмжээнээс хамааран 2 ангилалд хуваана.

I - хийн даралт 2.5 – 10.0 МПа /25-100 кгс/см<sup>2</sup>/

II - хийн даралт 1.2 – 2.5 МПа /12-25 кгс/см<sup>2</sup>/

Нефть болон нефть бүтээгдэхүүн дамжуулах хоолойг түүний диаметрээс хамааран 4 ангилалд хуваана.

I - 1000-1200 мм

II - 500-1000 мм

III - 300-500 мм

IV - 300 мм ба түүнээс бага

2.1.2. Дамжуулах хоолойнууд нь шатах, тэсрэх аюултай объектод тооцогдох тул тэдгээрт аюулгүй байдлын өндөржүүлсэн шаардлага тавигдана.

2.1.3. Мөнх цэвдэг хөрстэй газарт дамжуулах хоолойг төмөр замын өртөө ба төмөр замын шугамтай огтлолцуулахдаа төмөр зам дээгүүр зориулалтын гүүрээр, доогуур хамгаалалтын гэр дотуур гаргана. Гэсэх үедээ суулт өгдөггүй буурь хөрстэй газар зам доогуур гаргахыг зөвшөөрнө. Гэсэлтийн үедээ суулт өгдөг хөрс нь газрын гадаргаас доош 25м-ээс ихгүй гүнд байгаа нөхцөлд дамжуулах хоолойг зам доогуур огтлолцуулах бол хөрс хайлж суулт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зураг төслийн ажлын явцад дулааны техникийн тооцоонд онцгой ач холбогдол өгч үндэслэлийг сайтар тогтоосон байвал зохино.

2.1.4. Объектуудыг төмөр замтай огтлолцуулахтай холбогдож замын ул шороо өргөтгөх, шинээр зам барих зэрэг нэмэгдэл арга хэмжээг авах шаардлагатай бол тэдгээрийг зураг төсөлд тусгах бөгөөд зураг төсөл, барилгын ажлын зардлыг нь хүсэлт гаргагч тал санхүүжүүлнэ.

2.2. Дамжуулах хоолойг төмөр замтай газар доогуур огтлолцуулах

2.2.1. Дамжуулах хоолойг төмөр замын ул шорооны далан доогуур гаргахаар зураг төслийг зохиох ба тийм боломжгүй нөхцөлд суурь бүтэц эзэмшигчийн олгосон техникийн нөхцөлийн дагуу Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр төмөр зам байрлах уулын сэтэрхий хэсэгт тавьж болно.

2.2.2. Дамжуулах хоолойг төмөр замтай эгц хөндлөн, огтлолцлын өнцөг 90° байхаар огтлолцуулна. Ул шорооны далангийн их бие дундуур хоолойг гарган огтлолцуулахыг хориглоно.

2.2.3. Дамжуулах хоолойг төмөр зам доогуур гаргаж огтлолцуулахдаа түүний гадна талын диаметрээс 200 мм-ээр их диаметр бүхий хамгаалалтын гэр дотор байрлуулна.

2.2.4. Хамгаалалтын гэрийн үзүүрийг төмөр замын шугамын тэнхлэгээс /хэрэв олон замтай бол захын замын тэнхлэгээс/ 50 метр, ул шорооны ёроолоос 5 метр, сэтэрхийн дээд ирмэгээс 3 метр, ус зайлуулах төхөөрөмжийн /кювет, уулын болон нөөцийн шуудуу гэх мэт/ захаас 3 метрээс багагүй зайд байхаар тооцож байрлуулна.

2.2.5. Дамжуулах хоолойн ашиглалт, үйлчилгээний зориулалт бүхий холбооны кабелиг хамгаалалтын гэр дотор эсвэл кабел тус бүрт зориулсан хоолой дотор байрлуулна.

2.2.6. Хамгаалалтын гэрийн хоёр талын төгсгөлийг цахилгаан тусгаарлагч материалаар чигжиж битүүлнэ.

2.2.7. Хамгаалалтын гэр дотор дамжуулах хоолой гэмтсэнээс хий болон нефть бүтээгдэхүүний хуримтлал үүсэхээс урьдчилан сэргийлж түүний нэг төгсгөлд нийтийн хэрэглээний төмөр замын захын замын тэнхлэгээс 40 метр, дагнасан хэрэглээний замын захын замын тэнхлэгээс 25 метрээс багагүй зайд тус тус сорох гуурсыг суурилуулна. Сорох гуурсны өндөр газрын гадаргаас дээш 5 метрээс доошгүй байна.

2.2.8. Цахилгаанжуулсан төмөр замын өртөөний зам болон суман шилжүүлэг доогуур дамжуулах хоолойг огтлолцуулахыг хориглоно.

2.2.9. Дамжуулах хоолойг төмөр замын суман шилжүүлэг, түүний зүрхэвчээс 10 метрээс, суулт, овойлт гардаг хөрс бүхий газар бол суман шилжүүлэг, түүний зүрхэвчээс 20 метрээс, гүүр, хоолой, хонгил, бусад хиймэл төхөөрөмж, байгууламжуудаас 30 метрээс багагүй зайд төмөр зам доогуур гаргана.

2.2.10. Уулын сэтэрхий хэсэгт байрлах төмөр замын доогуур дамжуулах хоолойг огтлолцуулахаар бол түүний хамгаалалтын гэрийн дээд цэгээс зам төмрийн ул хүртэл 2 метр, ул шорооны далан доогуур бол хамгаалалтын гэрийн дээд цэгээс далангийн ёроол хүртэл 2 метрээс тус тус багагүй зайтай байхаар зураг төслийг зохиосон байвал зохино.

### 2.3. Дамжуулах хоолойг төмөр замтай газар дээгүүр огтлолцуулах

2.3.1. Дамжуулах хоолойг төмөр замын шугам болон нийтийн болон дагнасан хэрэглээний замууд дахь бүх төрлийн гүүрээр гаргахыг хориглоно.

2.3.2. Дамжуулах хоолойг дагнасан хэрэглээний зам дээгүүр огтлолцуулахдаа дамжуулах хоолойг дангаар нь эсвэл түүнд зориулан барьсан гүүрээр гаргана.

2.3.3. Дамжуулах хоолойн доод цэгээс эсвэл түүнд зориулан тусгайлан барьсан гүүрийн дам нурууны доод цэгээс зам төмрийн толгой хүртэлх зайг **MNS 5833:2014 /"төмөр зам барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"/** стандартын дагуу тогтооно.

2.3.4. Дамжуулах хоолойн гүүрийн тулгуурыг ул шорооны ёроолоос 5 метрээс, сэтэрхийд бол түүний дээд ирмэгээс 3 метрээс буюу захын зам төмрөөс 10 метрээс багагүй зайд байрлуулна. **Дамжуулах хоолойн тулгуурыг төмөр замыг өргөтгөх, хос зам тавих нөхцөлийг харгалзан үзсэн байвал зохино.**

2.3.5. Өртөөний замууд хооронд дамжуулах хоолойн гүүрэн гарцын завсрын тулгуур байрлахаар бол **MNS 5833: 2014 /"төмөр зам барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"/**стандартыг баримтална.

### 2.4. Дамжуулах хоолойн төмөр замд ойртох хязгаар

2.4.1. Дамжуулах хоолойг төмөр замтай зэргэлдээ тавихдаа түүний ангиллаас хамаарч журмын хавсралт 1-д заасан зайнаас ойр зайд байрлуулахыг хориглоно.

## **Гурав. Инженерийн шугамыг төмөр замтай огтлолцуулах**

3.1. Дулааны шугам. Дулааны шугамыг төмөр замтай огтлолцуулахдаа түүний доогуур болон дээгүүр огтлолцуулна. Дулааны шугамыг хамгаалалтын суваг, гэр, хонгилгүйгээр төмөр замтай огтлолцуулахыг хориглоно.

### 3.1.1. Дулааны шугамыг төмөр замтай газар доогуур огтлолцуулах

3.1.1.1. Дулааны шугамыг төмөр замын ул шорооны далан доогуур гаргахаар зураг төслийг зохиох ба онцгой нөхцөлд суурь бүтэц эзэмшигчийн олгосон техникийн нөхцөлийн дагуу зөвхөн Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр сэтэрхийд хийж болно.

3.1.1.2. Дулааны шугамыг төмөр замтай эгц хөндлөн огтлолцуулна. Шаардлагатай бол огтлолцлын өнцөг 60°-аас багагүй байна.

3.1.1.3. Дулааны шугамыг барьж байгуулах, сэргээн засварлах, зорилгоор гүйцэтгэх газар шорооны ажлыг ил ухаж дулааны шугамыг шууд угсрах боломжтой бол тусгайлсан сувагчлалыг хийж түүний дотор дулааны шугамыг байрлуулна.

3.1.1.4. Төмөр замын доогуур гарах огтлолын урт 40 метр хүртэл хэмжээтэй боловч огтлолцлын төгсгөлөөс цааш хоёр тал руугаа 10-15 метрийн хэмжээтэй шулуун хэсэг гаргаж болохуйц газарт дулааны шугамыг ил аргаар хийх боломжгүй нөхцөлд зөвхөн хамгаалалтын гэр хийж дотуур нь дулааны шугамыг сүвлэх аргаар барьж байгуулна. Бусад нөхцөлд болон дулааны шугамыг газрын гадаргаас 2.5 метр ба түүнээс бага гүнд байрлуулахаар байвал түүнийг тусгай хонгил дотор байрлуулна.

3.1.1.5. Суваг, хамгаалах хоолой, туннелийн урт нь захын замын тэнхлэгээс 50 метр, ул шорооны доод ирмэгийн шугамаас 5 метр, сэтэрхийн дээд ирмэгээс 3 метр, ус зайлуулах суваг, уулын шуудуу, нөөцийн сувгийн ирмэгээс 3 метрээс тус тус багагүй байвал зохино.

3.1.1.6. Суваг, хамгаалалтын гэр, хонгилын төгсгөлүүдэд үзлэгийн худаг хийж өгнө.

3.1.1.7. Төмөр замын доогуур огтлолцуулсан дулааны шугамын хамгаалалтын хийцийн дээд ирмэгээс газрын гадарга хүртэл зай нь 1 метрээс багагүй байна. Ул шорооны далангийн их бие дундуур дулааны шугам, хамгаалах суваг, хоолой, хонгилыг хөндлөн гаргаж болохгүй.

3.1.1.8. Дулааны шугамыг төмөр замын доогуур гарган огтлолцуулахдаа суман шилжүүлгийн төгсгөлөөс 10 метрээс, суулт өгөх хөрс бүхий газар бол суман шилжүүлгийн төгсгөлөөс 20 метрээс, гүүр, хоолой, хонгил бусад хиймэл төхөөрөмж, байгууламжуудаас 30 метрээс тус тус багагүй зайд гаргана.

3.1.1.9. Дулааны шугам, цахилгаанжуулсан төмөр замын тэнхлэг хоорондын зай 10.75 метрээс, дулааны шугам, төмөр замыг цахилгаанжуулахад зориулан босгосон цахилгааны шон хүртэлх зай 3.0 метрээс тус тус багагүй байна.

### 3.2.1. Дулааны шугамыг төмөр замтай газар дээгүүр огтлолцуулах

3.2.1.1. Дулааны шугамыг төмөр замын шугамтай огтлолцуулахдаа дээгүүр нь гаргах техникийн шийдлийг сонговол зохино. Харин байнгын ашиглагдаж буй авто замын болон төмөр замын гүүрээр түүнчлэн ус нэвтрүүлэх хоолой дотуур тавьж огтлолцуулж болохгүй.

3.2.1.2. Дулааны шугамыг цахилгаанжуулсан төмөр зам дээгүүр гаргахдаа дулааны шугамын цахилгаан дамжуулах чанар бүхий бүх эд анги, элементүүдийг огтлолцоос хоёр тийш 5 метрээс багагүй зайд 10 Ом-оос багагүй эсэргүүцэл бүхий газардуулгаар хангасан байвал зохино.

3.2.1.3. Дулааны шугамыг төмөр зам дээгүүр гаргах үед түүнийг хамгаалалтын гэрээр хамгаалж болно.

3.2.1.4. Зам төмрийн толгойн түвшнээс дулааны шугамын болон түүний алслалтын байгууламжийн доод түвшин хүртэлх зай, дулааны шугамын тулгуур, төмөр замын тэнхлэг хоорондын зайг MNS 5833: 2014 /"төмөр зам барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"/ стандартын шаардлагын дагуу тогтооно.

3.3. Цэвэр усны шугам, бохирын шугам, үерийн коллектор, цахилгааны агаарын шугам болон төрөл бүрийн зориулалтын кабел шугамуудыг төмөр замтай огтлолцуулахдаа дараах барилгын норм дүрмийн холбогдох заалтуудыг баримтална:

3.3.1. Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж. /БНБД 40-02-06/;

3.3.2. Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж. / БНБД 40-01-14 /;

3.3.3. Усан хангамж, бохир ус, гадна шугам, сүлжээ, түүний барилга байгууламж /БНБД 3.05.04-90/;

3.3.4. Цахилгаан байгууламжийн дүрэм /БД 43-101-03/;

## **Дөрөв. Авто зам, явган хүний зориулалттай гарцыг төмөр замтай огтлолцуулах**

### 4.1. Авто замыг төмөр замтай огтлолцуулах

4.1.1. Авто замыг төмөр зам хөндлөн гаргахдаа түүний доогуур болон дээгүүр, мөн нэг түвшинд огтлолцуулна.

4.1.2. Шинээр төсөллөж байгаа авто замыг /Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016/ төмөр замтай зөвхөн өөр түвшинд огтлолцуулна. Дараах тохиолдолд IV-V зэргийн авто замыг төмөр замтай өөр түвшинд огтлолцуулна:

4.1.2.1. Хоёр болон түүнээс олон төмөр замыг авто зам огтолж байвал;

4.1.2.2. Огтлолцох газарт зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөний хурд 100 км /цаг ба түүнээс их буюу хоногт 40 ба түүнээс илүү галт тэрэг явдаг замд;

4.2. Орон нутгийн чанартай авто замыг салбар төмөр замтай ижил түвшинд огтлолцуулах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэж "Төмөр замын гарам ашиглах журам"-аар зохицуулна.

### 4.3. Авто замыг төмөр замтай дээгүүр огтлолцуулах

4.3.1. Авто замыг төмөр зам дээгүүр гүүрээр гаргах ба төмөр замын хөгжлийг харгалзан зам төмрийн толгойноос дээш гүүрийн дам нурууны доод цэг хүртэлх зай болон гүүрийн тулгуур, эд ангиудаас төмөр замын тэнхлэг хүртэлх зайг MNS 5833 : 2014 /"төмөр зам барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"/ стандартын дагуу тогтооно.


### 4.4. Авто замыг төмөр замтай газар доогуур огтлолцуулах

4.4.1. Авто замыг төмөр зам доогуур огтлолцуулахдаа хонгил байгуулан огтлолцуулах ба түүний дээд цэгээс зам төмрийн ул хүртэл өндрийг 1.2 метрээс багагүй байх техникийн нөхцөлийг баримталбал зохино.

4.4.2. Хонгилын хийцийн тооцоог галт тэрэгний ачаалал, тэдгээрийн онцлогуудыг харгалзан тооцож зураг төслөөр тогтооно.

#### 4.4.3 Авто замын хонгил байгуулахдаа явган хүний гарцыг байгуулж өгнө.

Зураг1. Авто замыг нэвтрүүлэх хонгилын хэмжээ



**П** - ашиглалт, үйлчилгээний зориулалттай явган хүний зам өргөн нь 1500 мм, I ба II зэргийн авто замтай хонгилд замын хоёр талаар, III ба IV зэргийн авто замтай хонгилд замын нэг талд байрлана.

**З** - хамгаалалтын зурвас нь I ба II зэргийн авто замтай хонгилд замын 2 талд, III ба IV зэргийн авто замтай хонгилд замын нэг талд байрлана.

**Г** - Хонгил дахь авто замын явах хэсгийн өргөн /мм-ээр/

Хүснэгт 2. Хонгилын хөндлөн огтлолын хэмжээ

| Хонгилын урт /м-ээр/ | Г-Хонгил дахь авто замын явах хэсгийн өргөн /мм-ээр/ |      |        |
|----------------------|--|------|--------|
|                      | Авто замын зэрэг                                     |      |        |
|                      | I  | II   | III-IV |
| 300 м хүртэл         | 9000   | 8500 | 8000   |
| 300 м дээш           | 8500   | 8000 | 7000   |

#### 4.5. Авто зам төмөр замд ойртох хязгаар

4.5.1. Суурин газрын гадна авто зам төмөр замыг зэрэгцүүлэн тавихаар бол тэдгээрийн зурвас газруудыг давхцуулахгүй байвал зохино. Тэнхлэг хоорондын зай 100 метрээс багагүй байна. Шаардлагатай тохиолдолд авто зам, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

## **Тав. Явган хүний зориулалттай гарцыг төмөр замтай огтлолцуулах**

### **5.1. Явган хүний зориулалттай гарцыг төмөр замтай огтлолцуулах**

5.1.1. Өртөө, зөрлөг, төмөр замын буудал орчмын 3 буюу түүнээс дээш замтай хэсэгт явган хүний зориулалттай гарцыг төмөр замтай зөвхөн ижил бус түвшинд, өртөө, зөрлөг хоорондын замд галт тэрэгний болон явган зорчигчийн хөдөлгөөний нягтралаас хамаарч гарцыг төмөр зам дээгүүр, доогуур, нэг түвшинд огтлолцуулж болно.

5.1.2. Өртөө, зөрлөг хоорондын зам нь хоногт 15 ба түүнээс дээш хос галт тэрэгний хөдөлгөөнтэй, явган зорчигчийн зорчих урсгал нь жилд 35000 хүн ба түүнээс илүү байдаг, хоорондын замд галт тэрэг 90 км/цагаас дээш хурдтай аялдаг газруудад явган хүний зориулалтын гарцыг ижил бус түвшинд хийнэ.

5.1.3. Гүүрэн болон нүхэн гарц, тэдгээрээс гарах шатны дээд талын хийцлэлийг битүү байхаар хийсэн байвал зохино.

### **5.2. Явган хүний зориулалттай гарцыг төмөр замын дээгүүр гаргах**

5.2.1. Явган хүний зориулалтын гүүрэн гарцны өндрийг зам төмрийн толгойн түвшинээс дээш гүүрийн дам нурууны доод цэг хүртэлх зай, гүүрийн тулгуур, эд ангиудаас төмөр замын тэнхлэг хүртэлх зайг MNS 5833: 2014 /"төмөр зам барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"/ стандартын дагуу тогтооно.

5.2.2. Гүүр болон шатны өргөнийг явган зорчигчийн тооноос хамааран тогтоох ба хэмжээ нь 2.25 метрээс багагүй байна. Шат нь хашлага, зорчигч явах чиглэл заагчтай байна.

5.2.3. Явган хүний гүүрэн гарцыг явган зорчигчдын аюулгүй байдлыг хангасан хийцлэлтэй байхаас гадна тусгай хэрэгцээт иргэд, ачаа тээш зөөвөрлөх 5 хэмийн налуу зам болон цахилгаан шаттай байна.

### **5.3. Явган хүн зорчих зориулалттай гарцыг төмөр замын доогуур гаргах**

5.3.1. Төмөр замын доогуур нүхэн гарц хийхдээ явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан хийцлэлтэй байхаас гадна тусгай хэрэгцээт иргэд зорчих боломжтой байна.

5.3.3. Нүхэн гарцны өргөнийг явган зорчигчийн тооноос хамааран тогтоох ба түүний дээд ирмэгээс зам төмрийн ул хүртэл өндрийг 1.0 метрээс багагүй байх нөхцөлийг хангасан байна.

5.3.4. Нүхэн гарцын хийцийн тооцоог галт тэрэгний ачаалал, тэдгээрийн онцлогуудыг харгалзан хийж тооцон зураг төслөөр тогтооно.

5.3.5. Нүхэн гарцнаас зорчигчийн тавцан руу гарах хоёр чиглэлийн шатны өргөн 2,0 метрээс багагүй байх ба зорчигч төмөр зам руу орох нөхцөлийг хааж хашлага хийсэн байвал зохино.



### 5.3.6. Нүхэн гарцыг үерийн ус зайлуулах систем, гэрэлтүүлэгээр тоноглоно.

5.4. Төмөр замын буудал орчим одоо ашиглагдаж байгаа явган хүний гарц нь хашлага, зарлан мэдээллэгч, гэрэлтүүлэг зэргээр тоноглогдсон байна. Ийм гарцын өргөн нь 3 метрээс, ачааны болон шуудангийн тэргэнцрүүд өнгөрдөг бол 4 метрээс багагүй байна.

### Зургаа. Туузан дамжуулгыг төмөр замтай огтлолцуулах

6.1. Туузан дамжуулгыг төмөр замтай дээгүүр болон доогуур огтлолцуулж болно.

6.2. Нийтийн болон дагнасан хэрэглээний төмөр замтай дээгүүр огтлолцуулахдаа туузан дамжуулгын доод цэгээс зам төмрийн толгойн дээд түвшин хүртэл зай, туузан дамжуулгын тулгуур, эд ангиудаас төмөр замын тэнхлэг хүртэлх зайг MNS 5833: 2014 /"төмөр зам барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ"/ стандартын дагуу тогтооно.

### Долоо. Уул уурхайн карьерын ойртолтын хязгаар

7.1. Нүүрс, ашигт малтмалын олборлолтын ил, далд уурхайн захын ирмэг, асгаас шороон овоолгын /отвал/ ёроолоос төмөр замын шугамын замын тэнхлэг хүртэл 500 метрээс багагүй зайтай байна.

7.2. Төмөр замын засварын ажилд зориулалттай чулуу болон шороо, хайрга олборлолтын ил карьерын зах нь төмөр замын тэнхлэгээс 100 метрээс багагүй зайд байна.

### Найм. Аюултай байгууламжийн ойртолтын хязгаар

8.1. Аюултай байгууламжийн төмөр замд ойртох хязгаарыг Засгийн Газрын 2019 оны 8 сарын 07-ны өдрийн 313-р тогтоолын 1-р хавсралтад заасан "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм", Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтад заасан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын холбогдох заалтуудыг баримтлан тогтооно.

### Ес. Хиймэл төхөөрөмжийг ашиглан төмөр замын доогуур тээврийн хэрэгсэл, мал нэвтрүүлэх, тавигдах шаардлага

9.1. Одоо ашиглагдаж буй төмөр замын гүүр, хиймэл төхөөрөмжөөр авто зам тавих ажлыг тухайн орон нутгийн холбогдох байгууллага, суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцөж Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

9.2. Шинээр төмөр замын доогуур авто зам огтлолцуулахдаа "авто замын гүүр ба хоолой төсөллөх" /БНБД 32.02.11/ нормыг дагаж мөрдөнө.

9.2.1. Тээврийн хэрэгслийг нэвтрүүлэн өнгөрөөхөд өргөн нь 6 м, өндөр нь 4.5 м-ээс багагүй;

9.2.2. Мал нэвтрэх өргөн нь 4 м, өндөр 2,5 м-ээс багагүй.

9.3. Тээврийн хэрэгсэл гарах хиймэл төхөөрөмж нь оврын хаалгаар тоноглогдсон байна. (Зураг 2)



Зураг 2. Хиймэл төхөөрөмж доогуур авто тээврийн хэрэгсэл өнгөрөөхөд зориулсан оврын хаалга, тэмдгүүдийн байршил

9.3. Оврын хаалганы хяналтын хөндлийн доод ирмэг хиймэл төхөөрөмжийн өндрөөс 20 см доор байрлана. Оврын хаалгыг хиймэл төхөөрөмжийн хоёр талд түүнээс 10-15 м-ийн зайд байгуулна. Хиймэл төхөөрөмж рүү олон зам ирсэн байвал оврын хаалганы хажуугаар өнгөрөх бололцоогүй газар уг хаалгыг байрлуулна. Оврын хаалган дээр "өндрийн хязгаарлал", "өргөний хязгаарлал" гэсэн замын тэмдгүүдийг тавина. "өндрийн хязгаарлал", "өргөний хязгаарлал" гэсэн тэмдгүүд нь хиймэл төхөөрөмжийн бодит хэмжээнээс 20-40 см бага хэмжээтэй тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхийг зөвшөөрнө гэсэн заалт болно.

Оврын хаалга болон хиймэл төхөөрөмжийн хана, тааз, тулгууруудыг гэмтээхээс сэргийлж байрлуулсан хашлага, хамгаалалтыг хар ба цагаан өнгийн будгаар алаглуулан будна.

----- оОо -----

Журмын хавсралт 1.

Дамжуулах хоолойн төмөр замд ойртох хязгаар

| Төмөр зам, түүний<br>объектууд  | Дамжуулах хоолойн тэнхлэгээс объект хүртэлх хамгийн бага зай /метрээр/ |              |              |               |                |                |  |              |                |              |               |                    |
|---|--|--------------|--------------|---------------|----------------|----------------|--|--------------|----------------|--------------|---------------|--------------------|
|   | Хий дамжуулах хоолой   |              |              |               |                |                | нефть, нефть<br>бүтээгдэхүүн дамжуулах<br>хоолой |              |                |              |               |                    |
|   | Дамжуулах хоолойн ангилал  |              |              |               |                |                |  |              |                |              |               |                    |
|   | I  |              |              | II            |                |                | IV   | III          | II             | I            |               |                    |
|   | Хоолойн диаметр /мм-ээр/   |              |              |               |                |                |  |              |                |              |               |                    |
|   | 300-<br>с бага   | 300-с<br>600 | 600-с<br>800 | 800-с<br>1000 | 1000-с<br>1200 | 1200-с<br>1400 | 300-<br>с бага                                   | 300-<br>с их | 300-<br>с бага | 600-с<br>800 | 800-с<br>1000 | 1000-<br>с<br>1400 |
| Төмөр замын шугам<br>хүртэл, (м)  | 75   | 125          | 150          | 200           | 225            | 250            | 75   | 100          | 50             | 50           | 75            | 100                |
| 20 метрээс бага урттай<br>дам нуруу бүхий төмөр<br>замын гүүр хүртэл, (м)                         | 30   | 50           | 100          | 150           | 175            | 200            | 30   | 50           | 30             | 30           | 30            | 50                 |
| 20 метрээс урт дам<br>нуруу бүхий төмөр<br>замын гүүр хүртэл<br>/усны урсгалын доод<br>талд/, (м) | 75   | 125          | 150          | 200           | 225            | 250            | 75   | 125          | 75             | 100          | 150           | 200                |
| Үйлдвэрийн төмөр<br>замын гүүр хүртэл, (м)  | -  | -            | -            | -             | -              | -              | -  | -            | 300            | 300          | 300           | 500                |